



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

20 23 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 10/16

Даланзадгад сум

Г

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам батлах тухай” 192 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Дээрх журмыг хэрэгжүүлж ажиллахыг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын дарга (захирал), эрхлэгч нарт даалгасугай.
4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАДРАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
10/16 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг

1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид “эд хөрөнгө” гэх-/ийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлаж устгах, данснаас хасах, тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсвийн дагуу худалдан авсан, Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийн дагуу өөрийн хөрөнгөөр худалдаж авах, эсхүл хуулийн этгээд, хувь хүнээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

1.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангах талаар тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээж, Орон нутгийн өмчийн газартай байгуулсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний дагуу зохицуулна.

1.4 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг баримтлана.

1.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэлтэй үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглалтын хугацаа нь дууссан буюу эсхүл элэгдлийн хэмжээ нь дуусаагүй боловч ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах саналыг энэ журамд заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

1.6 Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хөрөнгөтэй холбоотой саналыг хүлээн авч, хянан үзээд эд хөрөнгийг бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах саналыг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санал авч, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, хуралдааны чөлөөт цагт Хурлын даргад¹ танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.7 Тухайн байгууллагын хувьд илүүдэлтэй буюу ашигладаггүй, эсхүл сэргээн засварлаж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон тээврийн хэрэгслийг зөвхөн дуудлагаар худалдахаар шийдвэрлэж, худалдах доод үнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хуралдааны чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлэн тогтооно.

1.8 Эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тогтоол, Хурлын даргын захирамжийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг заасан хугацаанд холбогдох материалын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх үүрэг хүлээнэ.

¹ ТБОНӨТ хуулийн 77.3 3. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ

1.9 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн харилцааны зарим асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас гадна Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц болон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрээр тусгайлан зохицуулсан тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.

Хоёр. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэхэд бүрдүүлэх материал

2.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурьдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ.

2.1.1 Орон нутгийн өмчийн оролцоотой ХК, ХХК-ийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн, шаардлагатай бол Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд харьяа Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөл;

2.1.2 Худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр;

2.1.3 Эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдан авах доод үнийн санал;

2.1.4 Хандив, тусламжаар хөрөнгө өгч буй байгууллагын үнэ тогтоож хүлээлгэн өгөх тухай албан бичиг, холбогдох материал, тухайн хөрөнгийг хүлээн авч буй байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үнэ тогтоосон дүгнэлт, хуралдааны тэмдэглэл;

2.1.5 Бусад шаардлагатай материал.

2.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.5-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурьдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ.

2.2.1 Орон нутгийн өмчийн оролцоотой ХК, ХХК-ийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн, шаардлагатай бол Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

2.2.2 Хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;

2.2.3 Холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;

2.2.4 Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт;

2.2.5 Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл маягтын дагуу;

2.2.6 Үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан;

2.2.7 Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ном, сэтгүүл, гарын авлагыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

2.2.8 Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, дүгнэлт;

2.2.9 Түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаар аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захирагааны төв байгууллагын санал;

2.2.10 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн биет болон биет бус үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоосон хэсгийг хуулбарлан, "Хуулбар үнэн" тэмдэгээр баталгаажуулж ирүүлэх;

2.2.11 бусад шаардлагатай баримт материал.

2.3 Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.2-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

2.3.1 Үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших (ашиглах) эрхийн санхүүгийн тайланд бүртгэсэн үнэлгээ, гэрчилгээ, газар эзэмшүүлэх (ашиглуулах) гэрээ, кадастрын зургийн хуулбар;

2.3.2 Үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын (зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт) болон ашиглалтын талаарх мэдээлэл;

2.3.3 Барилгын паспортын хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг;

2.3.4 Үл хөдлөх хөрөнгийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж, өмчилдөг тохиолдолд тухайн барилгыг бүхэлд нь зураглан, хөршүүдтэй хамтран баталсан заагийн актын хуулбар;

2.3.5 Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, худалдах бол түүнд ногдох газрын хэмжээ, үнэлгээ, гэрчилгээ, кадастрын зураг (салгаж хийлгэсэн);

2.3.6 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг хуваах, нэгтгэх, шилжүүлэх зэргээр өөрчлөлт орж байгаа нөхцөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт;

2.3.7 Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-д заасны дагуу тухайн байгууллагын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон тухай аймаг, сумын Засаг даргын шийдвэр, холбогдох материал.

2.4 Тээврийн хэрэгслийн хувьд энэхүү журмын 2.2-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

2.4.1 Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн торгууль, албан татвар, агаарын бохирдлын төлбөргүй тухай лавлагаа;

2.4.2 Техникийн үзүүлэлт, 3 талаас нь авсан өнгөт фото зураг;

2.4.3 Төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн мэдээлэл, холбогдох баримт;

2.4.4 Тээврийн хэрэгслийн сэргээн босголтын зардлыг техник ашиглалтын дэвтэрт баталгаажуулсан байх;

2.4.5 Тээврийн хэрэгслийн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгт орсон тухай лавлагаа;

2.4.6 Ашиглалтад орсон он, балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл болон бусад мэдээллийг холбогдох байгууллагаас баталсан "Тээврийн хэрэгслийн маяг"-ын дагуу гаргаж ирүүлэх.

2.5 Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэхүү журмын 2.2, 2.4-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

- 2.5.1 Механизм, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын хуулбар;
 - 2.5.2 Барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл;
 - 2.5.3 Бусад шаардлагатай баримт материал.
- 2.6 Биет бус хөрөнгийн хувьд энэ журмын 2.2-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.
- 2.6.1 Тусгай зөвшөөрөл, патент, лиценз бүхий биет бус хөрөнгийн эрхийн бичгийн хуулбар, актлах, устгах, шилжүүлэх болсон үндэслэл;
 - 2.6.2 Программ хангамжийн нэр, үнэ, элэгдэл хорогдол, лиценз эзэмшигч болон ашиглалтын талаарх мэдээллийг жагсаалтаар ирүүлэх;
 - 2.6.3 Бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших /ашиглах/ эрхийн гэрчилгээ, кадастрын зургийн хуулбар, тухайн газар дээрх барилга, байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар;
- 2.7 Энэхүү журам нь өмч хувьчлалын хөтөлбөрөөр хуулийн дагуу явуулах дуудлагын худалдаанд хамаарахгүй.

Гурав. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах

- 3.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.
- 3.2 Орон нутгийн өмчит төсөвт байгууллагын дарга /захирал/ нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган, саналыг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд нь жил бүрийн 08 дугаар сарын 01-ний дотор, Орон нутгийн өмчийн газарт эд хөрөнгө худалдан авах жагсаалтаа ирүүлнэ.
- 3.3 Эд хөрөнгө худалдан авах жагсаалтад тоо хэмжээ, үнийн дүн /үнэ/, хүчин чадал, техникийн үзүүлэлт, бусад шаардлагатай тайлбар тодорхойлолтыг тусгана.
- 3.4 Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө худалдан авах жагсаалтыг судлан, байгаа нөөц, хэрэгцээ шаардлага, хөрөнгийн ашиглалтын хугацаа норм норматив, зах зээлийн үнэ ханш, санхүүжилтийн эх үүсвэрийг баримтлан хянаж саналыг 06 дугаар сарын 01-ний дотор холбогдох төсвийн захирагчид, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд бизнес төлөвлөгөөнд тусгагдах хөрөнгө худалдан авах саналыг хянан үзэж саналыг 09 дүгээр сарын 01-ний дотор Төлөөлөн удирдах зөвлөлд нь хүргүүлнэ.
- 3.5 Орон нутгийн өмчийн газрын эд хөрөнгө худалдан авах саналыг харгалzan дараа оны тухайн төсвийн захирагчийн төсөвт суулгах асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.
- 3.6 Хөрөнгө худалдан авах захиалгаа өгөөгүй, хөрөнгө худалдан авах саналаа хянуулаагүй, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн бол энэ журмын 9.1-д заасны дагуу хариуцлага тооцно. Эх үүсвэр нь тодорхой буюу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн онд худалдан авахаар төлөвлөгөөнд орж батлагдсан хөрөнгийг зөвшөөрөлтэй гэж үзэх ба эх үүсвэр нь тодорхойгүй, өөр зардлаас шилжүүлж бэлтгэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл аваагүй бэлтгэсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй гэж үзнэ.

3.7 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө худалдан авах үнийн дээд хязгаарыг Орон нутгийн өмчийн газар тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэр, тээврийн хэрэгслийн тухайд эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо, төрөлд багтаан хянаж тогтооно

3.8 Орон нутгийн өмчит төсөвт байгууллага, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эх үүсвэр нь тусгагдаагүй боловч ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үндсэн хөрөнгө худалдаж авах тохиолдолд үндэслэл, санхүүгийн эх үүсвэрээ эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлсний үндсэн дээр Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авна.

3.9 Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эх үүсвэр нь батлагдаагүй боловч Эрчим хүч, уул уурхай, авто зам, Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын хувьд онцгой байдал үүссэн, ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үндсэн хөрөнгө худалдан авах тохиолдолд тодорхой үндэслэл, хөрөнгийн эх үүсвэрээ шийдвэрлэн Орон нутгийн өмчийн газарт саналаа тавьж зохих зөвшөөрөл авна.

3.10 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө, хандив, банкны зээл, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах, нийгэмчилсэн, өр төлбөрт тооцон авсан, дайчилсан буюу хураан авах журмаар эд хөрөнгө олж авбал энэ тухай Орон нутгийн өмчийн газарт мэдэгдэж, уг хөрөнгийг бүртгэлд тусгана.

3.11 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, өөрийн чиг үүрэгт өөрчлөлт орсон, хариуцах ажлын цар хүрээ өргөжсөн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан үйлчилгээний автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.12 Орон нутгийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авахдаа илүүдэлтэй буюу ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах саналаа хамтад нь хүргүүлж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.13 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох газрын алба, сумдын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших /ashiглах/ эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх

4.1 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, энэ журамд заасны дагуу зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд нь тухайн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу Монгол хэлээр зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.

4.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь банкны зээл, хандив, тусламж бэлэглэл, өр төлбөрт тооцон үл хөдлөх хөрөнгө олж авбал тухай бүр Орон нутгийн өмчийн газарт мэдэгдэж, уг хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна.

4.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын

бүрэлдэхүүнд Орон нутгийн өмчийн газрыг төлөөлөн ажилласан мэргэжилтэн тухайн барилга, объектын санхүүгийн тайланд тусгах үнэ өргтийг тооцсон акт материалыг хүлээн авч эзэмшигч байгууллагыг тогтоон, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

4.4 Гадаад дотоодын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусlamж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн албан ёсны зөвшөөрлийг бичгээр авсны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалzan ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна.

4.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээ, тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч шууд данс бүртгэлдээ тусгана.

4.6 Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусlamж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд холбогдох дээд байгууллага эсвэл Орон нутгийн өмчийн газарт асуудлаа хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.7 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр орон нутгийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэхдээ дараах материалыг бурдуулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.7.1 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, уг шийдвэрт шилжүүлэх хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээ, нэр төрөл, байршил, чанар байдлыг тодорхой тусгасан байх;

4.7.2 Шилжүүлэн авах үндсэн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгах байгууллагад энэ талаар мэдэгдэж, зөвшөөрөл, саналыг авсан байх.

4.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгийг Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолыг үндэслэн ашиглагч байгууллагын нягтлан бodoх бүртгэлд тусгана.

4.9 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын шийдвэрээр орон нутаг дахь төрийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсний үр дүнд бий болсон хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийн засварын зардлыг тухайн төрийн өмчит байгууллагын нягтлан бodoх бүртгэлд бүртгэж болно. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр бий болсон үл хөдлөх хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэж, тухайн төрийн өмчит байгууллагад “Ашиглалтын гэрээ”-гээр ашиглуулах ба урсгал засвар үйлчилгээг тухайн байгууллага бүрэн хариуцна.

4.10 Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусах хүртэл захиалагч байгууллага нь “бусад эргэлтийн хөрөнгө” дансанд бүртгэн санхүүгийн тайланд тусгана.

4.11 Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бodoх бүртгэлийн Олон улсын стандартын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ.

4.12 Улс болон орон нутгийн төсөв, хандив, бэлэглэл, тусlamжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн орон нутгийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд

тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээрийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй хургуулж шийдвэрлүүлнэ.

4.13 Төсөвт байгууллагын зөвшөөрөлгүй бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хураан авч, хэрэгцээ, шаардлагатай байгууллагад шилжүүлэх асуудлыг Орон нутгийн өмчийн газар хариуцан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлж болно.

4.14 Орон нутгийн өмчийн оролцоотой компанийд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа орон нутгийн өмчийн хувь оролцоог нэмэгдүүлэхээр Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан саналыг Орон нутгийн өмчийн газар хянан үзээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

4.15 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн дүрмийн санг нэмэгдүүлэхээр Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан саналыг жилд 1 удаа буюу дараа оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

Тав. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

5.1 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар орон нутгийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашиглалтгүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлнэ.

5.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын даргын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.3 Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогdon гарах зардлыг шилжүүлж авсан байгууллага хариуцна.

5.4 Орон нутгийн өмчит байгууллагуудын хооронд үл хөдлөх хөрөнгийг шилжүүлж байгаа тохиолдолд газар эзэмших эрх нь хамт шилжинэ.

5.5 Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн өгсөн этгээд өөрийн эзэмшилд байгаа эзэмших, ашиглах эрхтэй газраас шилжүүлэх үл хөдлөх хөрөнгөд ногдох газрын хэсгийг хэмжиж, зураглал хийлгэн, хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй хамтран газар, барилгын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага, Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авна. Уг зөвшөөрлийг үндэслэн газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийн шилжүүлэх (гэрчилгээ гаргуулах) арга хэмжээ авна.

5.6 Орон нутгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлж, гарсан шийдвэрийг үндэслэн тухайн байгууллага хөрөнгийн хөдөлгөөн хийнэ.

5.7 Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.8 Элэгдэл, хорогдлын шимтгэлээр өртгөө нөхсөн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхдээ энэ журмын 7.1-д заасны дагуу тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа

болон үнийг шинэчлэн тогтоох саналын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлж Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлнэ.

Зургаа. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг актлаж данснаас хасах

6.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг актлаж данснаас хасах тухай саналаа энэ журамд заасан баримт материалын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлж Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлнэ.

6.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр, бусад хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргын шийдвэрээр дараах тохиолдолд данснаас хасна.

6.2.1 Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон хөдлөх хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

6.2.2 Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон эд хөрөнгө;

6.2.3 Балансын үнийг бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон хөдлөх хөрөнгө;

6.2.4 Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцогоор нотлогдсон хөдлөх хөрөнгө.

6.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхдээ энэхүү журамд заасан мэдээллээс гадна дор дурдсан зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна:

6.3.1 Данснаас хасах эд хөрөнгийн тодорхойлолт;

6.3.2 Тоо хэмжээ, хөрөнгийн талаарх бусад мэдээлэл;

6.3.3 Данснаас хасах болсон шалтгаан;

6.3.4 Уг эд хөрөнгийг актлаж устгах эсвэл актлаж сэлбэгээр ашиглах тухай санал, хүсэлт;

6.3.5 Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл /сум, байгууллага/, дүгнэлт;

6.3.6 Байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт, дүгнэлт.

6.4 Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хянан үзэж энэ журмын 1.6-д заасны дагуу шийдвэрлүүлнэ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын даргын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бурдэл, чанар байдал, бүрэн бүтэн байлгах асуудлыг байгууллагын удирдлага хариуцаж, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдвал хариуцлагыг зохих хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нар хүлээнэ.

6.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын дарга нь үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

- 6.5.1 Эд хөрөнгийг худалдах;
 - 6.5.2 Эд хөрөнгийг шууд устгалд оруулах;
 - 6.5.3 Бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлэх;
 - 6.5.4 Сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;
 - 6.5.5 Газар дээрх болон газар доорхи барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх;
 - 6.5.6 Барилга байгууламжийн хувьд тухайн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх.
- 6.6 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэг бүрийн үнэ нь 5,000,000 (таван сая) төгрөг хүртэл үнэтэй үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгсэл /мотоцикл/-ээс бусад хөдлөх хөрөнгийг энэ журмын 6.3-д заасны дагуу материалыг бүрдүүлэн данснаас хасах шийдвэр гаргаж болох бөгөөд шийдвэрлэсэн тухай тогтоолыг хавсралтын хамт Орон нутгийн өмчийн газарт тухай бүр хүргүүлнэ.
- 6.7 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор үндсэн хөрөнгийг актлаж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор өмч хамгаалах Байнгын зөвлөлөөрөө хэлэлцэн, устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусган тайланг тухай бүр Орон нутгийн өмчийн газарт заавал ирүүлнэ.
- 6.8 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын даргын шийдвэрээр автомашин, механизмыг акталж, сэлбэгээр худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд тэдгээр хөрөнгийг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах арга хэмжээг өмч эзэмшигч байгууллага хариуцна.
- 6.9 Акталсан тээврийн хэрэгслийг сэлбэгээр худалдан авсан этгээдэд тээврийн хэрэгслийн улсын дугаар шилжүүлэхийг хориглоно.

Долоо. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түүний үнийг шинэчлэн тогтоох

- 7.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэлтэй эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртөгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлнэ.
- 7.2 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Орон нутгийн өмчийн газартай зөвшилцэн тогтоож, дахин данс бүртгэлд тусгаж болно.
- 7.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 7.1, 7.2-д заасан асуудлаар саналаа бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхдээ дараах баримт материалыг хамт ирүүлнэ.

- 7.3.1 Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах зардлын тооцоо, үндэслэл;
- 7.3.2 Эрх бүхий байгууллагаар хийлгэсэн хөрөнгийн үнэлгээ (шаардлагатай тохиолдолд);

7.3.3 Өмнө нь эрх бүхий байгууллагаас гаргасан хөрөнгө акталж, данснаас хасах шийдвэр;

7.3.4 Хөрөнгийн ашиглалтын талаар гарсан мэргэжлийн байгууллагын дүгнэлт (шаардлагатай тохиолдолд)

7.3.5 Ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцэн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт;

7.3.6 Хөрөнгийн жагсаалтыг Орон нутгийн өмчийн газраас баталсан маятаар (нэр, тоо ширхэг, ашиглалтад орсон он, шинэчлэн тогтоох үнийн санал, ашиглалтын хугацааг сунгах санал);

7.3.7 Бусад шаардлагатай баримт материал.

Найм. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах

8.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж устгах талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын даргаас гарсан шийдвэрийг тухайн байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөл хэрэгжүүлж, тухайн хуулийн этгээдийн дарга (захирал) хяналт тавина.

8.2 Эд хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах шийдвэрийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих үүргийг тухайн хуулийн этгээдийн дарга (захирал), нягтлан бодогч нар бүрэн хариуцна.

8.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг 14 хоногийн дотор устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүng холбогдох данс бүртгэлд тусгана.

8.4 Эд хөрөнгө олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, актласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хурлын даргын шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

8.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээд олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, актласан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг хагас жил болон жилийн эцэст “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний хавсралтын дагуу гаргаж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

8.6 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, актласан эд хөрөнгийн хөдлөлийн мэдээ тайланг хагас, бүтэн жилээр “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн программд оруулна.

8.7 Тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах тухай шийдвэрийн биелэлтийг орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхдээ Автотээврийн үндэсний төвөөс автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хассан тухай лавлагааг авсан байна.

Ес. Хариуцлага

9.1 Энэ журмыг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

9.2 Энэ журам болон эд хөрөнгө олж авах, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах, бүртгэхтэй холбогдон гарсан бусад хууль тогтоомж, журмыг зөрчсөн, холбогдох

мэдээллийг санаатайгаар худал мэдээлсэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд болон төсөвт учирсан хохирлыг буруутай этгээд хариуцах бөгөөд учирсан хохирлыг бүрэн барагдуулаагүй тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлэх арга хэмжээ авна.

9.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг хариуцах бөгөөд зөрчил дутагдал гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Арав. Бусад

10.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл тооцоход тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгийн данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх тухай хүсэлтийг Орон нутгийн өмчийн газраас гаргасан маягтын дагуу гаргаж зөвшөөрөл авсны үндсэн дээр хөрөнгийн хөдлөлийг хийж бүртгэлд тусгана.

10.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлана.

10.3 Эрх бүхий байгууллагын шийдвэр, Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана.

10.4 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгсэл, машин механизмаас бусад хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах тухай асуудлыг шийдвэрлэж болох ба уг тогтоолыг тухай бүр Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

10.5 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизмыг худалдах, балансаас балансад шилжүүлэх, актлах саналыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан энэ журамд заасны дагуу материалыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж, уг саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөөт цагт Хурлын даргаар шийдвэрлүүлнэ.

10.6 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар эд хөрөнгө олж авах, бүртгэх асуудлыг хэлэлцэхэд энэ журмыг удирдлага болгоно.

10.7 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэ журмыг баримтлан ажиллана.

10.8 Байгууллагын дарга, захирал /эрхлэгч/ нар нь эд хариуцагч буюу няравтай "Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ"-г байгуулж ажиллах бөгөөд эд хариуцагч нь картаар хөрөнгө эзэмшиж буй ажилтантай Орон нутгийн өмчийн газраас баталсан "Ажилтан албан хаагчтай байгуулах эд хөрөнгийн ашиглалтын гэрээ"-г байгуулан ажиллана.

10.9 Байгууллагын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх хөрөнгө /амархан эвдэрч гэмтэж болзошгүй тоног төхөөрөмж/ зэргийг даатгуулахдаа мэргэжлийн оролцогч болох зуучлалын байгууллагаар дамжуулан даатгалыг хийлгэнэ.